



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар A/198

Арвайхээр сум

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны өрөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хайрхандулаан сумын цэцэрлэгийн засвар ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хурээний агентлаг Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Г.Нармандах (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хурээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын Нягтлан бодогч)

Т.Энхтайван (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Б.Ууганбаяр (Өвөрхангай аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга тэргүүн) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичиг:

М.Санчир (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хурээний агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа, гэрээ хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Ц.Идэрсайхан)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (М.Санчир)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

И.ДОРЖСҮРЭН

6224 11 0410

D:My Doc. Zahiramj. Zasag darga